



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 8.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг өөрчлөх зайлшгүй шаардлага, төсвийн зарим ерөнхийлөн захирагчдийн саналыг харгалзан Сангийн сайдын 2011 оны 1 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын 2011 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарийг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2011 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь”-ийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын төсвийн багцын санхүүжилтийн 5-12 дугаар саруудын хуваарийг энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын дагуу, 3 дугаар хавсралтаар батлагдсан Улсын төсвөөс 2011 оны төсвийн жилд орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг энэхүү тушаалын 3 дугаар хавсралтын дагуу, 5 дугаар хавсралтаар батлагдсан Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн сар, улирлын хуваарийг энэхүү тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу, 7 дугаар хавсралтаар батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр 2011 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сарын хуваарийг энэхүү тушаалын 5 дугаар хавсралтын дагуу, 8 дугаар хавсралтаар батлагдсан Эрчим хүчний алдагдлын 2011 оны татаасын хуваарийг энэхүү тушаалын 6 дугаар хавсралтын дагуу тус тус өөрчилсүгэй.

Хоёр. Төсвийн шинэчилсэн хуваарийг мөрдөн ажиллахыг Төрийн сангийн газар /Х.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

САЙД



С.БАЯРЦОГТ